

ХСИС-ИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ “МАНСУУРУУЛАХ БОДИС, СЭТГЭЦЭД НӨЛӨӨЛӨХ ЭМ, БЭЛДМЭЛИЙН ХУУЛЬ БУС ЭРГЭЛТТЭЙ ТЭМЦЭХ АРГА ЗҮЙ” ХИЧЭЭЛИЙГ ОРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

THE NECESSITY FOR INTEGRATING THE COURSE ON COMBATTING DRUG CONSUMPTION INTO THE CURRICULUM OF LAW ENFORCEMENT UNIVERSITY



Г.ТАМИР

ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Нийгмийн ажлын тэнхимийн эрхлэгч, хурандаа

TAMIR G.

Head of social work department, Court Decision Enforcement Institute, Law Enforcement University

Товч агуулга: Хууль сахиулахын их сургууль нь сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг эрх зүйн шинэчлэлийн бодлого, зорилготой уялдуулах, нөгөө талаас улс орны эрүүгийн нөхцөл байдал, гэмт явдлын бүтэц, хөдөлгөөн, прогнозыг харгалзан боловсруулах шаардлагатай.

Монгол Улс мансууруулах бодисын хэрэглээгээр дэлхийд доогуурт бичигдэж байгаа ч энэ байдал удаан үргэлжлэхгүй гэдэг нь олон хүчин зүйлүүдээр нотлогдож байна.

Мансууруулах бодисын хууль бус эргэлттэй гэмт хэрэгтэй хийх тэмцлийн үр дүн хууль сахиулах салбарын боловсон хүчний мэдлэг үр чадвартай шууд холбоотой.

Иймд Монгол Улсын хууль сахиулах салбарын мэргэжилтэн бэлтгэдэг гол сургууль болохын хувьд ХСИС нь “Мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тактик” хичээлийг бүрэлдэхүүн сургуулиудын сургалтын хөтөлбөрт оруулж, багшлах бүрэлдэхүүнийг мэргэшүүлэх, сургалтын хэрэглэгдэхүүн, материаллаг орчныг сайжруулах шаардлагатай байна.

Abstract: The curriculum of Law Enforcement University needs to be developed taking into account such factors as current policies on legal reform, crime trends, and criminological situation and prognosis of the country.

Though Mongolia has lower level of illegal drug use in the world, there are certain factors that might increase the level in the future. The knowledge and skills of law enforcement staff will certainly play an important role in combatting illegal drug consumption and drug-related crimes. Therefore, as one of the major universities which train and develop law enforcement staff in Mongolia, Law Enforcement University is required to integrate the course on “Methods and techniques for combatting illegal drug use and drug-related crimes” into its curriculum and start educating teaching staff and developing teaching materials of the course.

Түлхүүр үгс: Хар тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис, хууль бус хэрэглээ, гэмт явдлын бүтэц, прогноз, чиг хандлага, сургалт

Key words: Drugs, psychotropic substances, the structure of crime, outlook, trends, training.

Хууль сахиулахын их сургуулийг байгуулах тухай Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 87 дугаар тогтоолд “...хууль сахиулах салбарын хүний нөөцийг бэлтгэх мэргэжлийн сургалтыг нэгдсэн зохион байгуулалтад төвлөрүүлж, сургалтын хөтөлбөр, агуулга, орчинг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх...” талаар дурджээ.

Тус сургууль нь сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг эрх зүйн шинэчлэлийн бодлого, зорилготой уялдуулах, нөгөө талаас улс орны эрүүгийн нөхцөл байдал, гэмт явдлын бүтэц, хөдөлгөөн, криминологийн прогнозыг харгалзан боловсруулах шаардлагатай. Тухайлбал: Монгол Улсад мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх

эм бэлдмэлийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн гаралт нэмэгдэж, энэ нь үндэсний аюулгүй байдлын хэмжээнд яригдах асуудлын нэг болсон талаар зарим эрдэмтэн, судлаачид¹ үздэг.

Монгол Улсад 1990 оноос хойш нийгэм, эдийн засаг, улс төр, оюун санаанд эргэлт гарч, олон ургалч үзэл, хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, дэлхий нийтийн даяаршилтай хөл нийлүүлэн алхахын хэрээр гэмт явдлын бүтэц хувьсан өөрчлөгдөж², шинэ төрлийн гэмт хэргүүд бүртгэгдэхийн зэрэгцээ элдэв гаж хэрэглээ, сонирхолд хөтлөгдөх явдал иргэдийн дунд ихсэх хандлагатай байна. Монгол Улс мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хууль бус эргэлтээр олон улсын хэмжээнд доогуур бичигддэг³ ч энэ байдал удаан үргэлжлэхгүй нь дараах зүйлүүдээс харагдаж байна. Тухайлбал:

Нэгдүгээрт: Улам бүр даяаршиж буй өнөө үед мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хууль бус үйлдвэрлэл, худалдаа, хэрэглээ нь дэлхий дээр тахал мэт хурдацтай тархаж байна. НҮБ-ын Мансууруулах бодис, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх албаны мэдээллээр мансууруулах бодис болон сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн үйлдвэрлэл сүүлийн 15 жилд 3 дахин нэмэгдсэн бөгөөд 269,4 сая хэрэглэгч байна.

ОХУ, БНХАУ нь мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт явдал, ХДХВ-ийн халдварын тархалтаар дэлхийд эхний дөрөвт багтаж байна.⁴ 2010 онд ОХУ-ын Мансууруулах бодист хяналт тавих төвийн тэргүүн Виктор Ивановын мэдэгдсэнээр тус улсын нийт хүн амын 3.5 хувь буюу 5 сая гаруйхун мансууруулах бодис хэрэглэдгээс 2.5 сая нь идэвхитэй донтогч байна. Энэ үзүүлэлтийг 2002 оныхтой харьцуулахад 2 дахин нэмэгдсэн бөгөөд дэлхийд 100 саяаас дээш хүн амтай улс орнуудаас хэрэглээгээрээ 1-рт бичигдэж байна.⁵

БНХАУ нь эрүүгийн ялын бодлогоороо мансууруулах бодистой хатуу тэмцдэг боловч энэ төрлийн гэмт хэрэг, хэрэглээ төдийлэн буурахгүй байна. Тус улсын мансууруулах бодисын зах зээлд 65 тэрбум ам.доллар эргэлдэж, 15 сая гаруй хүн донтож, жил бүр мансууруулах бодисын хэрэглээнээс болж 100 мянган хүн насбардаг гэсэн судалгааг НҮБ-ын Мансууруулах бодис, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх албанаас хийсэн байдаг.⁶

Монгол Улсын иргэд хоёр хөршид чөлөөтэй зорчих, нөгөө талаас хөрш улсын иргэд ч бизнесийн болон бусад зорилгоор тус улсад тодорхой хугацаагаар оршин суух явдал ихсэх болсон. Түүнчлэн, 2014 оны эхний хагас жилийн байдлаар энэ төрлийн гэмт хэрэгт гадаад улсад Монгол Улсын 37 иргэн ял эдэлж байгаа⁷ нь мансууруулах бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт явдал, хэрэглээ нэмэгдэх хандлагатайг харуулж байна.

Хоёрдугаарт: Монгол Улсад мансууруулах бодистой холбоотой гэмт хэргийн

¹ http://www.antidrug.mn/index.php?option=com_content&view=article&id=8:2013-05-03-15-56-03&catid=1:tamhinii-hor-urshig&Itemid=17

² Ж.Мөнхболд “Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх хууль бус эргэлтийн эсрэг ажиллагаа” УБ, 2013

³ <http://mongolian.mongolia.usembassy.gov/03/01/010.html>

⁴ http://www.antidrug.mn/index.php?option=com_content&view=article&id=8:2013-05-03-15-56-03&catid=1:tamhinii-hor-urshig&Itemid=17

⁵ <http://www.forbes.com/2009/07/10/russia-narcotics-trade-business-oxford.html>

⁶ <http://www.gia.gov.mn>

⁷ <http://www.gia.gov.mn/articles/view/82> /Монгол Улсын Тагнуулын ерөнхий газрын мэдээлэл/

гаралт, энэ төрлийн гэмт хэрэгт холбогдсон иргэдийн тоо жил ирэх тусам өсөх боллоо. Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Хар тамхи, мансууруулах бодисын аюул, урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга зам” сэдэвт нээлттэй уулзалтын үеэр “...Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд энэ чиглэлийн нэлээд мэдээлэл ирж байна. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанаас гаргасан мэдээллээр мансууруулах бодис хэрэглэж буй хүмүүсийн тоо 16000 хүрсэн байна. Олон улсын хэмжээнд нэг хэрэглэгчийн ард дөрвөн далд хэрэглэгч байдаг гэж үздэг бөгөөд энэ аргачлалаар бодож үзэхэд 64000 гэсэн тоо харагдаж байна. Энэ бол Монгол Улсын нэг аймгийн хүн амтай тэнцэхүйц тоо харагдаж байна. Ийм тоо сонсоод бид цочирдохгүй, түгшүүр төрөхгүй байх аргагүй байна...”⁸ гэж анхааруулсан байдаг.

Манай улсад 2010 онд мансууруулах бодистой холбоотой 15 гэмт хэрэг бүртгэгдэж байсан бол 2012 онд 36 гэмт хэрэгт 171, 2013 онд 34 хэрэгт 74, 2014 оны эхний 6 сарын байдлаар 12 хэрэгт 27 хүн буюу хоёр жил гаруйхан хугацаанд нийт 272 хүн энэ төрлийн гэмт хэрэгт холбогджээ.⁹

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн статистикийн мэдээллээр сэтгэцэд нөлөөлөх бэлдмэлийн шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд 1999 онд 10,000 хүнд 7.5% байсан бол 2008 онд 14.1 % болж нэмэгдсэн байна.¹⁰ Нөгөө талаас тус улс нь нэг хүнд ноогдох согтууруулах ундаа, архины хэрэглээгээрээ дэлхийн дунджаас хоёр дахин илүү¹¹ байгаа нь хар тамхины хэрэглээ хурдан тархах магадлалтайг харуулж байна.

Гуравдугаарт: 2014 оны жилийн эцсийн байдлаар мансууруулах бодистой холбоотой гэмт хэргээр 27 ялтан хорих ял эдэлж байв.¹² Хорих ял эдэлж буй хүмүүсийн дотор мансууруулах үйлчилгээтэй ургамал, эм бэлдмэлийг сонирхон судлах, энэ төрлийн хэрэгт шийтгүүлсэн хүмүүсээс хэрэглээний талаар асуух, даган дуурайж хэрэглэх, сэтгэцэд нөлөөлөх үйлчилгээтэй ургамлыг түүж цуглуулах, хатааж бэлтгэх явдал практик байгууллагад удаа дараа гарч байсныг дурдах нь зүйтэй. Монгол Улсын хэмжээнд дунджаар 6-7 мянга гаруй хүн хорих ял эдэлдэг бөгөөд эдгээрээс чухам хэдэн нь мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хэрэглэдэг, мансуурах донтой болохыг тодорхойлох тоо баримт, судалгааны материал байхгүй, энэ чиглэлээр тогтмол судалгаа хийх механизм бий болоогүйг анхаарах шаардлагатай болжээ.

Дөрөвдүгээрт: Монгол Улсын хэмжээнд мансууруулах бодис агуулсан ургамлын тархац өндөртэй 14 аймаг байдаг бөгөөд төвлөрсөн 23 хорих анги эдгээр тархац өндөртэй нутагт байршиж байгаа нь хорих ял эдлэгсдийн зүгээс мансууруулах бодис хэрэглэх нөхцөл бололцоог бий болгох сөрөг талтай байна.

Хорих байгууллагад ажиллаж буй албан хаагчдаас мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийн талаар хэр мэдлэгтэй вэ? гэсэн асуултанд судалгаанд хамрагдсан алба хаагчдын 55 хувь нь сайн мэдэхгүй, 23 хувь нь огт мэдэхгүй гэж хариулсан бол мансуурсан хүнд ямар шинж тэмдэг илэрдэг вэ? гэсэн

⁸ Ц.Элбэгдорж. Хар тамхитай холбоотой гэмт хэрэгт өршөөлгүй. Өдрийн сонин. №053 /4517/ 2012.03.05

⁹ Б.Бямбабаатар. Мансуурах донтой этгээдийг хорих ял эдлүүлэхэд анхаарах зарим асуудлууд. Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал., 2014.№4 (12)

¹⁰ <http://ncmh.gov.mn/?cat=6>

¹¹ <https://www.dorgio.mn/news/society/attention/10137>

¹² ШШГЕГ-ын “Тоо бүртгэл, судалгааны ажлын 2014 оны тайлан”

асуултанд бүгд мэдэхгүй гэсэн хариулт өгсөн. Энэ судалгааг ХСИС-ийн ШШГС-ийн эчнээ ангид суралцагч буй 60 суралцагчаас авсан бөгөөд тэдгээрийн ихэнх нь хорих байгууллагын харуул хамгаалалтын үндсэн бүрэлдэхүүн болох хянагч албан тушаалд ажилладаг, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй төвлөрсөн 27 хорих ангийн төлөөлөл болох боломжтой гэж судлаачийн зүгээс үзсэн болно.

Хорих байгууллагын ажилтан албан хаагчид мансууруулах бодисын талаар зохих мэдлэггүй, түүнээс урьдчилан сэргийлэх тухай нэгдсэн ойлголтгүй, мансуурах донтой, мансуурсан этгээдтэй ажиллах, мансууруулах бодисыг илрүүлэх, таних чадваргүй, энэ чиглэлийн сургалт, мэдээлэл явагддаггүй зэргээс үзэхэд хорих байгууллагад мансууруулах бодис нэвтрэх, ял эдлэгсэдийн дунд хэрэглээ үүсэх, тархах нөхцөл байдал бий болжээ гэсэн дүгнэлтийг хийж болохоор байна.

Монгол Улсад хар тамхи, мансууруулах бодисийн хэрэглээ нэмэгдэхийн хэрээр энэ төрлийн гэмт хэрэгт шалгагдаж байгаа болон ял шийтгүүлсэн хүмүүс эсвэл мансуурах донтой этгээд хорих байгууллагад хоригдох тохиолдолд тэднийг нийгэмшүүлэх, гаж зуршил, амьдралын хэв маягийг өөрчлөх, эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх, хар тамхи, мансууруулах бодис хорих байгууллагад нэвтрэхээс урьдчилан сэргийлж, илрүүлэх, хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах, энэ чиглэлд боловсон хүчнийг бэлтгэх шаардлага шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын өмнө тулгарч байна.

Хар тамхины хэрэглээ, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх асуудалд боловсон хүчний мэдлэг, ур чадвар чухал үүрэгтэй.

Иймд цагдаа, хил хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдал зэрэг хууль сахиулах ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэдэг байгууллагуудын хүний нөөцийг бэлтгэдэг тус их сургууль нь сургалтын бодлого, хөтөлбөрөө боловсруулахдаа дээрх нөхцөл байдлыг харгалзан үзэх шаардлагатай болжээ. Өөрөөр хэлбэл, хууль сахиулах их сургуулийг төгсөж буй албан хаагч бүр мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн төрөл, сэтгэцэд үзүүлэх нөлөөлөл, хор уршиг, тэдгээрийг таних, илрүүлэх, мансуурсан, донтсон этгээдэд илрэх шинж тэмдэг, зан төрх, тэдэнтэй ажиллахад анхаарах асуудал, мансуурлын зэрэг тогтоох, илрүүлэх багаж, хэрэгсэл, тэдгээрийг ашиглах арга зүйн талаар мэдлэг, ур чадвар эзэмшсэн байхыг цаг үе шаардаж байна.

Түүнчлэн, мансуурлын зэрэг тогтоогч тест, мансуурах, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийг илрүүлэх, шинжлэн судлах техник хэрэгсэл, лабораторийг судалж оруулах, тэдгээрийг ашиглах мэдлэг, ур чадварыг хууль сахиулах байгууллагын албан хаагчдад олгох шаардлагатай.

Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт явдалтай тэмцэхэд ХСИС-ын сургалтыг чиглүүлэх хэрэгцээ, шаардлага сэдвийн хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. “Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт явдалтай тэмцэх тактик” хичээлийг бүрэлдэхүүн сургуулиудын сургалтын хөтөлбөрт оруулж, хичээлийн хөтөлбөр, цаг сэдвийн төлөвлөгөөг хөтөлбөрийн хороогоор хэлэлцэх эсвэл бусад хичээлүүдийн агуулгыг дээрх сэдвээр баяжуулах;

2. Бүрэлдэхүүн сургууль бүрт дээрх чиглэлээр мэргэшсэн багш бэлтгэх, мэргэшүүлэх, сургалтанд хамруулах;

3. Хичээлийн хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд наркологийн төв, хил, гааль, шүүхийн шинжилгээний алба болон олон улсын байгууллагуудтай

хамтран ажиллах;

4. Сургалтын материаллаг баазыг бэхжүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөр боловсруулж, олон улсын хандивлагч байгууллагуудад санал хүргүүлэх;

5. “Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт явдалтай тэмцэх” сургалтын кабинет, лабораторийг байгуулах; (Мансуурах, сэтгэцэд нөлөөлөх бодистой холбоотой үзүүлэн таниулах материал, хар тамхи илрүүлэх, мансуурлын зэрэг тогтоох сэтгэцэд нөлөөлөх бодис, эм бэлдмэлийн ялган таних, шинжлэн судлах техник, хэрэгсэл гэх мэт сургалтын хэрэглэгдэхүүн, материаллаг орчныг бүрдүүлэх)

6. Дээрх чиглэлийн нэг сэдэвт бүтээл, сурах бичиг, ном гарын авлага бүтээх ажлыг эрчимжүүлэх, бүтээл боловсруулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх зэрэг болно.